



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/91

Ховд

Тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны н/19 дүгээр тушаалаар батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.4, 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ашиглагдаж байгаа онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийн 2021 оны хагас жилийн тооллогыг 6 дугаар сарын 03-наас 04-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Ганхуяг - Цэргийн штабын дарга, хурандаа

Гишүүд: Д.Одгэрэл - Дайчилгааны офицер, дэд хурандаа

Д.Тамир - Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, ахмад

2. Онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийг нэг бүрчлэн хуудас бүрээр нь тоолон, дүнг 6 дугаар сарын 04-ний өдрийн дотор танилцуулан, актыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг комиссын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2021 тг А/91 Kh
02 0562